

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

АУДИТЫН КОД: ГСА-2023/28-6-ШТА-ГА

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор:
Б.Сарантуяа, Утас: 70543179
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр,
Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179
Цахим хаяг: darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

Тайланг бэлтгэсэн:

**Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар**

**Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа**

**Аудитын менежер
Г.Наранбаяр**

**Ахлах аудитор
Б.Дарханбат**

**Аудитор
С.Батцэцэг**

**Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70543179
дугаарын утсаар
харилцана уу.**

ХАЯГ:

**Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 213 тоот**

2023 оны 04 дүгээр сар

АГУУЛГА

АГУУЛГА 2

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говьсүмбэр аймагт хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт 83.3%, Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичигт 100% нийцсэн байна. 8

А.1. Төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна. . 8

А.2.Шинээр хэрэгжих 3 барилга байгууламжийн ажлаас 1 буюу 33.3 хувь нь хууль батлагдсаны дараа төсөвт өртгийг шинэчлүүлэн магадлалаар баталгаажуулсан байна. 9

Улсын төсвөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд тавих хяналт сул байгаа нь хууль тогтоомж зөрчигдөх шалтгаан болж байна. 10

Б.1 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.10

Б.2 Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа, ковид-19 цар тахлын улмаас Төсвийн тухай хуульд заасан хугацаанд ашиглалтад ороогүй, удааширсан 2 барилга байгууламж байна.11

Б.3 Санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслээгүй, гэрээний хугацаанд олгоогүй байна.11

Б.4 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд ТЕЗ-ийн дотоод аудит болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.13

Б.5 Төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан боловч нягтлан бодох бүртгэлд бүрэн бүртгэж тайлагнаагүй байна.14

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний бэлэн байдал, үр ашгийг бодитой тооцоогүйгээс 158.0 сая төгрөгийн ашиглалтгүй хөрөнгө бэлтгэсэн байна. 15

В.1 Орон нутгийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төлөвлөлтийн шаардлага хангаагүй 2 төсөл, арга хэмжээ батлагдсан байна.15

В.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн өмнөх оноос сайжирсан боловч төлөвлөлтөөс шалтгаалсан зөрчил давтагдан гарсаар байгаа нь хэрэгжилт, үр дүнд сөргөөр нөлөөлж байна.16

Дүгнэлт

Зөвлөмж

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлан баталгаажуулах тушаал

Тайлангийн хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГС

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ГСА	Говьсүмбэр аймаг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨАГ	Орон нутгийн өмчийн газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ҮАХ	Үйл ажиллагааны хөтөлбөр
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
ХАА	Худалдан авах ажиллагаа
ЭЗНХҮЧ	Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь заалтыг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоол, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх;
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн эсэх;

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Авто замын тухай хууль
- “Алсын хараа” 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр
- Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам” болон холбогдох бусад аргачлал
- Батлагдсан зураг төсөв, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ, бусад холбогдох эрхзүйн актууд

Аудитын хамарсан
хүрээ:

Аудитад улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг 2022 онд хэрэгжүүлсэн ТЕЗ болон тэдгээрийн харьяа байгууллагууд аймгийн ЗДТГ, ГХБХБГ, ОНӨГ болон холбогдох бусад гүйцэтгэгч аж ахуй нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, ХАА-ны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудит хийлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт” Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүр төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор С.Батцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатыг 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс эхлүүлж, тайланг Тэргүүлэх аудиторов тушаалаар баталгаажуулан шалгагдагч байгууллага болон холбогдох эрх бүхий албан тушаалтанд 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр хүргүүлээ.


Хүндрэл бэрхшээл:

Хүний нөөцийн хүрэлцээгүй байдлын улмаас аудиторууд цаг хугацааны хувьд давхардалтай 3 аудитад зэрэг ажилласан нь хүндрэл бэрхшээл учруулж байлаа.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд Говьсүмбэр аймагт 40,517.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээ батлагджээ. Үүнээс шинээр хэрэгжих 11,855.6 сая төгрөгийн 4, шилжих 28,661.6 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ байна. Тухайн жилд 9,310.9 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

2022 онд батлагдсан төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртгийн хэмжээг өмнөх онтой харьцуулбал:



2021 онд 9 төсөл, арга хэмжээг 23,114.2 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бол 2022 онд 10 төсөл, арга хэмжээг 40,517.2 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг өмнөх оноос 17,403.0 сая төгрөг буюу 43%-иар өсжээ. Энэ нь “Нэгдсэн эмнэлгийн барилга”-ын төсөвт өртөг 11,143.3 сая төгрөг болж 1,300.0 сая төгрөгийн гадна инженерийн шугам сүлжээний ажил нэмэгдэж батлагдсанаас шалтгаалжээ.

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль нэр зааж батлагдсан, харьяалах ТЕЗ нь эрх шилжүүлсэн 4 төсөл, арга хэмжээний худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтаар, нэр зааж батлагдаагүй боловч харьяалах ТЕЗ-ийн багцаас эрх шилжсэн 1 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг аймгийн ИТХ-ын 2021 оны 05 дугаар тогтоолоор 2,192.5 сая төгрөгийн 15, 2022 оны 08 дугаар тогтоолоор төсвийн тодотгол хийж 3,587.8 сая төгрөгийн 49 төсөл, арга хэмжээг баталжээ.

Орон нутгийн өмчийн газраас ТЕЗ-ийн худалдан авах төлөвлөгөөнд батлагдсан 25 төсөл, арга хэмжээ, Сүмбэр сумын ЗДТГ-ын 1 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны үр дүнгээр 2,610.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 төсөл, арга хэмжээг 100% цахимаар зохион байгуулж 22 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2,219.4 сая төгрөгийн гэрээ байгуулах эрхийг захиалагчид олгож худалдан авах ажиллагаанаас 52.3 сая төгрөгийн гэрээний хэмнэлт үүссэн байна.

Дүрслэл товьёг

<i>№</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
<i>Дүрслэл 1</i>	2022 онд батлагдсан төсөл, арга хэмжээг салбараар ангилсан дүрслэл	8
<i>Дүрслэл 2</i>	Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	8
<i>Дүрслэл 3</i>	Хөгжлийн бодлогын уялдаа	15

Хүснэгтийн товьёг

<i>№</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
<i>Хүснэгт 1</i>	2022 онд эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний жагсаалт	10
<i>Хүснэгт 2</i>	2022 онд эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээнд олгосон санхүүжилтийн жагсаалт	12
<i>Хүснэгт 3</i>	Нэмэлт гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний жагсаалт	13
<i>Хүснэгт 4</i>	Хэрэгжээгүй 7 төсөл, арга хэмжээний жагсаалт	17
<i>Хүснэгт 5</i>	Зураг төсөв зохиогчийн хяналт тавих шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт	19

БҮЛЭГ 1

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говьсүмбэр аймагт хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт 83.3%, Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичигт 100% нийцсэн байна.

А.1. Төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна.

А.1.1. Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд нэр, байршил зааж батлагдсан 10, харьяалах ТЕЗ-ийн багцад батлагдсан 2 нийт 12 төсөл, арга хэмжээ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн байна.

А.1.2. Батлагдсан төсөл, арга хэмжээ нь улсын хөрөнгө оруулалтын 2021-2025 оны хөтөлбөрт тусгагдаагүй бөгөөд Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-т заасны дагуу 30 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг уг хөтөлбөрт хамруулдагтай холбоотой байна.


Говьсүмбэр аймагт 2022 онд 30 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээ батлагдаагүй байна.

Харин аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй 83.3%, аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй 75.0 хувь нь нийцж байна. Үүнд салбарын яамны бодлогоор хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хэрэгцээ шаардлагын дагуу санал авдаггүйтэй холбоотой.


А.1.3 2022 онд батлагдсан төсөл, арга хэмжээг салбараар нь авч үзвэл:

Дүрслэл №1

(сая төгрөгөөр)



Дүрслэлээс харахад: Боловсрол 39%, эрүүл мэнд 28%, Хөдөө аж ахуй 5%, хууль сахиулах 7%, дэд бүтцийн салбар 21%-ийг тус тус эзэлж байна. Дээрх төсөл, арга хэмжээнүүд нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийг хангахуйц, бүс болон орон нутгийн хөгжлийн бодлогын уялдааг хангасан, эерэг өөрчлөлтийг бий болгож байна. Тухайлбал:



(Эх сурвалж: Боловсрол, эрүүл мэндийн статистик)

Аймгийн нэгдсэн эмнэлгийн барилга ашиглалтад орсноор зөвхөн аймгийн иргэд бус Говьсүмбэр аймагтай хил залгаа Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан, Дундговь аймгийн Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан, Хэнтий аймгийн Дархан, Баянжаргалан сумдын хүн амд эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэн эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж сайжирч хэвтэн эмчлүүлэгсдийн тоо 2019 онтой харьцуулахад 2022 онд 23%-иар буюу 1.1 мянгаар нэмэгджээ.

А.2.Шинээр хэрэгжих 3 барилга байгууламжийн ажлаас 1 буюу 33.3 хувь нь хууль батлагдсаны дараа төсөвт өртгийг шинэчлүүлэн магадлалаар баталгаажуулсан байна.

А.2.1 Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд Говьсүмбэр аймагт хэрэгжүүлэхээр баталсан 10 төсөл, арга хэмжээнүүд нь тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой байна. Үүнээс 2022 оны байдлаар хэрэгжиж дууссан Цагдаагийн хэлтсийн барилга, Нэгдсэн эмнэлгийн барилгууд нь ашиглагч байгууллагуудын өмчлөлд шилжсэн байна.

А.2.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг Сангийн сайдын 2018 оны 295, 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан аргачлал, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу эрэмбэлэн нийгэм, эдийн засгийн ач холбогдол, төслөөс бий болох үр өгөөжийг урьдчилан төлөвлөх зохицуулалттай байна.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь дээрх журмын дагуу төслийн үр ашиг, нийгмийн ач холбогдолтой байдлыг цахимаар эрэмбэлэн тогтоож, аймгийн Засаг даргын 2022 оны 04 сарын 29-ний өдрийн А/555 тоот албан бичгээр 21, 2021 оны 07 сарын 19-ний өдрийн А/814 тоот албан бичгээр 12 төсөл, арга хэмжээний саналыг 10 ТЕЗ-д хүргүүлжээ.

Батлагдсан төсөл, арга хэмжээнээс “Их соёл-Эх үндэс” төсөл нь Говьсүмбэр аймагт эрэмбэлэгдээгүй бөгөөд Соёлын яамнаас эрэмбэлсэн байна.

А.2.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хуулийн шаардлага хангаагүй 2 барилга байгууламжийг төлөвлөсөн байна.

Аудитын илрүүлэлт: Зөвлөмж

“Шивээговь сумын 150 ортой цэцэрлэгийн барилга нь Төсвийн тухай хуулийн төлөвлөлтийн шаардлагыг хангаагүй бөгөөд хууль батлагдсаны дараа төсөв нь магадлалаар баталгаажсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29¹.2.2¹, 29.4², Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2³, 3.2.2.1⁴, 3.2.2.2⁵ заасныг тус тус зөрчсөн байна. Дээрх зөрчил гарахад төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг эрэмбэлж байгаа нь нөлөөлсөн ба магадлалаар баталгаажсан зураг төсөв, холбогдох зөвшөөрөл нь гараагүй байхад худалдан авах ажиллагааг эхлүүлэх нь барилгын ажил удааширах, хуулиар батлагдсан төсөвт өртөг нэмэгдэх зэрэг эрсдэлийг үүсгэж байна.

Уг зөрчил жил бүр давтагдан гарч байгаа нь аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга, мэргэжилтнүүд тогтвор суурьшилтай ажилладаггүй, хүний нөөц, боловсон хүчний дутагдал үүссэн нь нөлөөлж байна.

¹ 29¹.2.2.барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх

² Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

³ 3.2.2.Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх дараахь шаардлагыг хангаагүй төслийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй

⁴ 3.2.2.1.эрх бүхий байгууллагаас газрын болон бусад төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд шаардлагатай зөвшөөрлийг авсан байх

⁵ 3.2.2.2.барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх

А.2.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсвийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр, холбогдох тооцоолол болон төсөвт нөлөөлөх ачааллыг Сангийн яамны Publicinvestment.gov.mn цахим системд тооцож оруулсан байна.

Системийн зохион байгуулалтаас шалтгаалан 1-р үе шатны үнэлгээг хийн төслийг салбарын ТЕЗ-д буюу 2-р үе шатанд шилжүүлсэн тохиолдолд 1-р үе шатны үнэлгээг хийсэн ТЕЗ-д дээрх төсөл арга хэмжээ системд харагддаггүй байна. Энэ нь аудитын хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжийг хязгаарлаж байна. Цаашид цахим системд оруулсан мэдээллийг цаасан хэлбэрээр баримтжуулах, төлөвлөлттэй холбоотой шаардлагатай мэдээлэлд хандах эрхийн тохиргоо хийх зэргээр нотлох баримт цуглуулах нөхцөл боломжоор хангах шаардлагатай байна.

А.2.5 2022 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1, 13.2 -т заасантай нийцэж байна. Харин Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх заалтууд нь 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтад хамаарах зохицуулалттай байна.

БҮЛЭГ Б

Улсын төсвөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд тавих хяналт сул байгаа нь хууль тогтоомж зөрчигдөх шалтгаан болж байна.

Б.1 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

Б.1.1 Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд шинээр хэрэгжих 4, шилжих 6 нийт 10 төсөл арга хэмжээ батлагдсанаас 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг тухайн салбарын ТЕЗ-аас аймагт эрх шилжүүлсэн байна. Мөн Говьсүмбэр аймагт нэр зааж батлагдаагүй боловч ЗГХЭГ-ын багцад батлагдсан 1 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын эрхийг шилжүүлэх ТЕЗ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.2.2⁶-т заасан хугацаанд эрх шилжүүлэх хуулийн зохицуулалттай бөгөөд 2022 онд эрх шилжүүлсэн 4 төсөл, арга хэмжээг журамд заасан хугацаанд шилжүүлсэн байна.

2022 онд эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний жагсаалт

Хүснэгт № 1

(сая төгрөгөөр)

Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Эрх шилжүүлсэн шийдвэр		
				Эрх шилжүүлсэн	Огноо	Дугаар
XIII.1.1.331	БШУС	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Шивээговь сум, 1 дүгээр баг/	2,200.0	ЗГ-ын тогтоол	2022-02-01	№61
XV.1.1.50	ЗТХС	Аймгийн төвийн авто замын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	3,300.0	ЗГ-ын тогтоол	2022-02-01	№61
XV.1.1.78	ЗТХС	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 6.9 км /Говьсүмбэр, Шивээговь сум/	5,355.6	ЗГ-ын тогтоол	2022-02-01	№61
V.1.3.3	ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, харьяа байгууллагуудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	50.0	ЗГХЭГ-тушаал	2022-01-07	№03
Нийт			10,905.6			

(Эх сурвалж: Орон нутгийн өмчийн албаны ХАА-ны тайлан, анхан шатны баримт)

Аймгийн Засаг даргын 2022 оны 02 сарын 22-ны өдөр баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд дээрх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг төлөвлөсөн байна. Эрх

⁶ 2.2.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн тохиолдолд шийдвэрийг тухайн жилийн 2 дугаар сарын 1-ний дотор гаргаж, ажлын 3-5 хоногт багтаан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

шилжүүлэн авсан аймгийн ТЕЗ төсөл, арга хэмжээг тухайн онд хэрэгжих боломжтой хугацаанд тендер шалгаруулалтыг зохион байгуулжээ.

Б.1.2 Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.1⁷-т заасны дагуу техникийн тодорхойлолт, тендерийн баримт бичигт тусгах шаардлагуудыг боловсруулж хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1⁸-т заасны дагуу захиалагчаар батлуулсан байна.

Б.1.3 Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах ажиллагааны журмыг баримтлан ажиллаж 3 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалт, 1 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргыг ашиглан “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ээр зохион байгуулж ил тод, нээлттэй өрсөлдөх боломжийг хангаж ажилласан байна.

Б.2 Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа, ковид-19 цар тахлын улмаас Төсвийн тухай хуульд заасан хугацаанд ашиглалтад ороогүй, удааширсан 2 барилга байгууламж байна.

Б.2.1 Говьсүмбэр аймагт улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй барилга байгууламжууд нь барилгын тухай хууль, авто замын тухай хуульд заасан шаардлагын дагуу баригдаж байна.

Аудитын илрүүлэлт: Зөвлөмж

Сүмбэр сумын 150 ортой цэцэрлэгийн барилга-1,508.6 сая, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилга-2,149.9 сая төгрөгийн ажлыг 2019 онд гэрээ байгуулан эхлүүлсэн боловч 4 жилийн хугацаанд барилгын ажил дуусаагүй удааширч анх төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад орох боломжгүй болсон байна. Анхны гэрээгээр 2021 онд ашиглалтад орох байсан боловч 3 удаагийн гэрээ сунгалтаар 2023 онд хүлээн авахаар өөрчлөлт оржээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр 29.3.5⁹-т заасныг зөрчсөн бөгөөд ковид-19 цар тахал, гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалж дээрх нөхцөл байдал үүссэн байна.

Б.2.2 Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд Говьсүмбэр аймагт их засварын ажил батлагдаагүй байна.

Б.2.3 Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд ЗГХЭГ-ын багцад 400.0 сая төгрөг батлагдсан бөгөөд үүнээс 50.0 сая төгрөгийг /тоног төхөөрөмж худалдан авах/ аймгийн ТЕЗ-д эрх шилжүүлжээ. Захиалагч нь харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж “Монтех дистрибьюшн” ХХК шалгарч 42.7 сая төгрөгөөр техникийн тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлтийг хангахуйц тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна

Б.2.2 Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд Говьсүмбэр аймагт ТЭЗҮ ангилалд төсөл, арга хэмжээ батлагдаагүй байна.

Б.2.5 Говьсүмбэр аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй дуусаагүй орхигдсон төсөл, арга хэмжээ байхгүй байна.

Б.3 Санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслээгүй, гэрээний хугацаанд олгоогүй байна.

⁷ 47.2.1.техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх;

⁸ 19.1.Захиалагч тендерийн баримт бичгийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам, аргачлалын дагуу бэлтгэнэ.

⁹ 29.3.5.шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;

Б.3.1 Тайлант хугацаанд 4,179.8 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээний санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын данснаас 3,942.8 сая, барьцаа хөрөнгийн данснаас 900.0 сая, нийт 4,842.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 2

(сая төгрөгөөр)

№	ТАХ-ий нэр	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих	Олгосон		2022 онд нийт олгосон
				Үндсэн данснаас	Барьцаа данснаас	
1	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум/	1,619.2	296.5	251.6		251.6
2	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Шивээговь сум, 1 дүгээр баг/	2,200.0	800.0	800.0		800.0
3	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2,200.0	450.0	-	700.0	700.0
4	Аймгийн төвийн авто замын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	3,300.0	1,000.0	1,000.0		1,000.0
5	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 6.9 км /Говьсүмбэр, Шивээговь сум/	5,355.6	200.0	200.0		200.0
6	Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/	7,609.8	1,390.6	1,648.5	200.0	1,848.5
7	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, харьяа байгууллагуудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	50.0	42.7	42.7		42.7
Нийт		22,334.6	4,179.8	3,942.8	900.0	4,842.8

(Эх сурвалж: Аудитын судалгаа, ХО-ын анхан шатны баримт материал, дансны хуулга)

Захиалагч буюу аймгийн ЗДТГ нь Дуу бүжгийн боржигин чуулгын барилгын ажил, ЗГХЭГ-ын харьяа байгууллагуудын санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.

Аудитын илрүүлэлт: Албан шаардлага

- Дуу бүжгийн боржигин чуулгын барилгын ажил нь Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд тухайн жилд 1,390.6 сая төгрөгөөр санхүүжих дүнтэй батлагдсан боловч 257.9 сая төгрөгийн санхүүжилтийг Сангийн яамнаас хөрөнгө оруулалтын дансанд шилжүүлсэн. Дээрх санхүүжилтийн гүйцэтгэлийг цонх, гадна фасад, шал, дээвэр гэх мэт хийгдээгүй ажлаар гарган 250.6 сая төгрөгийг гүйцэтгэгч компани болох “Хөшиг-Уул” ХХК-д олгожээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.6¹⁰, Засгийн газрын 2021 оны 160-р тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.2.9¹¹-т заасныг тус тус зөрчсөн байна. Аймгийн ЗДТГ нь батлагдсан санхүүжилтийг буцаан татуулахгүй гэсэн шалтгаанаар бодит гүйцэтгэлээс зөрүүтэй гүйцэтгэлийг баталгаажуулсан нь дээрх зөрчил гарах шалтгаан нөхцөл болсон бөгөөд бодит гүйцэтгэлээс зөрүүтэй гүйцэтгэл баталгаажуулах нь залилан, ашиг сонирхол, албан тушаалын гэмт хэрэг үүсэх үр дагавартай байна.
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, харьяа байгууллагуудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ ажлын нийлүүлэгч “Монтех Дистрибьюшн” ХХК 2022 оны 06 сарын 15-нд тоног төхөөрөмжийг тоо хэмжээгээр нь нийлүүлсэн боловч аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн ажил хариуцсан мэргэжилтнүүд солигдсоны улмаас 2022 оны 12 сарын 14-ний өдөр санхүүжилтийг олгосон байна. Энэ нь захиалагч гүйцэтгэгчтэй байгуулсан

¹⁰ 41.2.6.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх;

¹¹ 2.1.2.9.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төслийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн санхүүжилтийг хянан баталгаажуулах

ЗГХЭГ/202202020 тоот гэрээний 5 дугаар зүйлийн 5.2.1-т заасныг зөрчсөн байна. Санхүүжилтийг хугацаанд нь олгоогүйгээс шалтгаалж нийлүүлэгч талд үүссэн хохирлыг хариуцах, гомдол гарах эрсдэлтэй асуудал үүссэн байна.

Б.3.2 Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоол батлагдсантай холбоотой Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 75 дугаар тушаалаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих барилга, байгууламжийн төсөвт өртгийн өөрчлөлтийг тооцох журам” батлагдсан байна. Эрх шилжин хэрэгжсэн 4 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч Барилгын хөгжлийн төвөөр магадлалын дүгнэлт гаргуулан материалын үнийн зөрүү тооцуулснаас 3 нь захиалагчтай нэмэлт гэрээ байгуулжээ.

Нэмэлт гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний жагсаалт

Хүснэгт №3

(сая төгрөгөөр)

2023 оны хуулийн №	Нэмэлт гэрээ байгуулсан төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Үндсэн гэрээ	Нэмэлт санхүүжил т	Нэмэлт гэрээ байгуулсан эсэх
IX.1.11	2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/	3,558.4	3,423.6	134.8	Тийм
X.1.1.43	Сургуулийн барилга, 640 суудал /Говьсүмбэр, Сүмбэр сум, 2 дугаар сургууль/	5,946.4	5,629.4	317.0	Үгүй
XI.1.38	Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/	8,261.7	7,609.8	651.9	Тийм
XIII.1.1	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2,408.1	2,149.9	258.2	Тийм
Нийт		20,174.6	18,812.7	1,361.9	

(Эх сурвалж: Магадлалын дүгнэлт, захиалагч гүйцэтгэгчтэй байгуулсан нэмэлт гэрээ

Дээрх 3 төсөл арга хэмжээний нэмэлт гэрээ нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох шаардлагад нийцсэн байна.

Б.4 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд ТЕЗ-ийн дотоод аудит болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Б.4.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжиж буй 6 төсөл арга хэмжээнд захиалагч болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээ байгуулсан байна. Аймгийн ЗДТГ болон ГХБХБГ захиалагчийн хяналтыг хамтран хэрэгжүүлж 68.5 сая, Шивээговь сумын 150 ортой цэцэрлэг болон Дуу бүжгийн Боржигин чуулгын зохиогчийн хяналтыг “Эл Энд Эйч” Констракшн, “Ориент Плюс” ХХК тус тус хэрэгжүүлж 16.2 сая төгрөгийн захиалагч болон зохиогчийн хяналтын санхүүжилт авчээ.

Мөн аймгийн төвийн авто зам, Шивээговь сумын 6.9 км хатуу хучилттай авто замын ажлыг аймгийн ГХБХБГ-аас “Танил санаа” ХХК-тай технологийн хяналт хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж хяналт тавьж ажилласан байна.

Аудитын илрүүлэлт: Зөвлөмж

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилгын ажлын зураг төсвийг зохиогч “Нарлаг хөхий” ХХК, Сүмбэр сумын 5-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг төсвийг зохиогч “Гандирс од” ХХК-иуд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, барилгын ажлын явцад зураг төсөв зохиогчийн хяналтыг тавиагүй байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн

37.1.5¹², Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178-р тушаалаар батлагдсан “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.1¹³, 4.2.3¹⁴, 4.2.4¹⁵-т заасныг зөрчсөн байна. Зохиогчийн хяналт хэрэгжээгүйгээс тухайн барилга байгууламж зураг төсвийн дагуу баригдахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Б.4.2 Орон нутагт аймгийн ТЕЗ-ийн дотоод аудитыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг бөгөөд 2022 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд дотоод аудит хийгээгүй байна. Өмнөх аудитаар аймгийн Засаг даргад дотоод аудит хэрэгжүүлэх зөвлөмжийг өгсөн боловч дээрх алдаа зөрчил давтагдан гарсан тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Б.5 Төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан боловч нягтлан бодох бүртгэлд бүрэн бүртгэж тайлагнаагүй байна.

Б.5.1 2022 онд эрх шилжин хэрэгжсэн 7 төсөл, арга хэмжээнээс ЗГХЭГ-аас эрх шилжин хэрэгжсэн “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, харьяа байгууллагуудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/” 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42.7 сая төгрөгийн гэрээтэй ажил бүрэн хэрэгжиж аймгийн Засаг даргын 2022 оны А/19 тоот захирамжаар байгуулсан ажлын хэсэг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээн авсан байна.

Б.5.2 Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтнүүд 2-3 удаа солигдсоноос шалтгаалан дээрх гэрээний үүргийн биелэлтийг 2022 оны 12 сарын 14-ний өдөр дүгнэн санхүүжилтийг олгосон байна.

Б.5.3 Орон нутгийн өмчийн газраас хүлээн авсан компьютер тоног төхөөрөмжийг бүртгэх шийдвэрийг аймгийн ИТХ-д хугацаа алдаж хүргүүлснээс шалтгаалан зарим байгууллагууд хүлээн авсан тоног төхөөрөмжийг бүртгэж тайлагнаагүй байна.

Аудитын илрүүлэлт: Албан шаардлага

Шивээговь, Баянтал сумын ЗДТГ-ууд 23.7 сая төгрөгийн 16 нэр төрлийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгалгүйгээр ашиглаж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, Засгийн газрын 2021 оны 160-р тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.31¹⁶-т заасныг тус тус зөрчсөн байна.

Хөрөнгө оруулалтаар хүлээн авсан тоног төхөөрөмжийг бүртгэхгүй байх нь хөрөнгө эзэнгүйдээж, дутагдах, зориулалт бусаар зарцуулах эрсдэлийг үүсгэж байна.

¹² 37.1.5.барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах;

¹³ 4.2.1.захиалагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр барилгын ажилд зохиогчийн хяналт тавих;

¹⁴ 4.2.3.барилгын ажлыг норм нормативын баримт бичиг, ажлын зургийн дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянах;

¹⁵ 4.2.4.барилгын материал, тоног төхөөрөмж, бүтээц, эдлэхүүн, бүтээгдэхүүнийн сертификат, паспорт, бусад техникийн бичиг баримтууд нь улсын стандарт, техникийн нөхцөл, зураг төслийн баримт бичигтэй тохирч байгаа эсэхийг хянах;

¹⁶ 4.1.31.Эцсийн санхүүжилтийг авахад тухайн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.

БҮЛЭГ В

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний
бэлэн байдал, үр ашгийг бодитой тооцоогүйгээс 158.0 сая
төгрөгийн ашиглалтгүй хөрөнгө бэлтгэсэн байна.

В.1 Орон нутгийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төлөвлөлтийн шаардлага хангаагүй 2 төсөл, арга хэмжээ батлагдсан байна.

В.1.1 Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 12 сарын 03-ны 05, 2022 оны 06 сарын 20-ны өдрийн 08 дугаар тогтоолоор 2022 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 3,587.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 49 төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталжээ. Эдгээр нь Монгол Улсын Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтод нийцэж байна.

Дүрслэл №3

Говьсүмбэр аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө



Аймгийн ЗДҮАХ, үндсэн чиглэлд 41 төсөл, арга хэмжээ буюу 83.6% нь нэр зааж батлагдсан бол 8 төсөл, арга хэмжээг ерөнхий нэршил, агуулгаар нь баталсан байна. Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, арга хэмжээ нь ерөнхий агуулгаараа дунд хугацааны бодлогын баримт бичигт нийцэх боловч хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг төлөвлөсөн арга хэмжээг үнэлж дүгнэх боломжтой байдлаар боловсруулаагүй байна.

В.1.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг аймгийн ЗДТГ нь төрийн байгууллагуудаас албан бичгээр хүлээн авч нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ЗДҮАХ-тэй нийцүүлэн төлөвлөдөг байна. Төсвийн тухай хуулийн 29¹.2.2.¹⁷, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.2.¹⁸ заасан шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй байх хууль, эрхзүйн зохицуулалттай байна.

¹⁷ 29¹.2.2.барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх

¹⁸ 3.2.2.2.барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх;

Аудитын илрүүлэлт: Зөвлөмж

“Сүмбэр сумын Найрамдал хотхонд шинээр баригдаж байгаа барилгуудын цахилгаан хангамжийн ажил”, “Халуун усны барилгын ажил”-ын зураг төсөл, төсөв нь тус тус магадлалаар баталгаажуулаагүй байхад төлөвлөсөн. Энэ нь өмнөх жилүүдэд техникийн нөхцөл олголт, ажлын даалгаврын өөрчлөлт, ковид-19 цар тахал зэргээс шалтгаалж зураг төсвийн ажлууд удааширсантай холбоотой байна.

Үүний нөлөөгөөр төлөвлөсөн төсөвт өртөгт өөрчлөлт орж төсөвт тодотгол хийх шаардлага үүссэн ба халуун усны барилгын ажлын төсөвт өртөг 157.0 сая, Найрамдал хотхонд шинээр баригдаж буй барилгуудын цахилгаан хангамжийн ажлын төсөвт өртөг 98.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх заалтууд 2023 оны төсвийн жилээс хэрэгжих бөгөөд аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг ажлуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1, 13.2-т заасныг мөрдөж ажилласан бөгөөд гэрээний хэмнэлт болон хэрэгжээгүй ажлын үлдэгдэл 1,176.8 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

В.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн өмнөх оноос сайжирсан боловч төлөвлөлтөөс шалтгаалсан зөрчил давтагдан гарсаар байгаа нь хэрэгжилт, үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

В.2.1 Аймгийн Орон нутгийн өмчийн газраас ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан 2,610.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 төсөл, арга хэмжээг 100% цахимаар зохион байгуулж 22 төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулж 2,209.3 сая төгрөгийн гэрээ байгуулах эрхийг захиалагчид олгож худалдан авах ажиллагаанаас 62.4 сая төгрөгийн гэрээний хэмнэлт үүссэн байна.

Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлагын дагуу үнэлгээ хийгээгүй шалтгаанаар “Монтех дистрибьюшн” ХХК-иас гомдол гарч Сангийн ямаар хянагджээ. Захиалагч буюу аймгийн ЗДТГ-ын дарга нь шууд гэрээ байгуулах босго үнийн хязгаарт багтсан 180.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээнээс 13 төсөл арга хэмжээнд 145.6 сая төгрөгийн гэрээ байгуулжээ.

Худалдан авах ажиллагаатай холбоотой анхан шатны баримт материалын бүрдлийг шалгахад үнэлгээний хорооны үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийн бүрдэл дутуу байна.

Аудитын илрүүлэлт: Зөвлөмж

15 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл, хурлын тэмдэглэлийг гарын үсгээр бүрэн баталгаажуулаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 103-р тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн сан бүрдүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.19¹⁹, 3.7.3²⁰-т заасныг тус тус зөрчсөн. Үнэлгээний хорооны хуралд зарим гишүүд цахимаар оролцдог, баримтжуулалтыг тухай бүр хийхгүй байгаа нь зөрчил гарах шалтгаан болсон байна.

В.2.2 Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 75.7 хувьтай, зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан шинэ болон шилжих 49 төсөл, арга хэмжээнээс шинээр хэрэгжих 2,427.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 35 төсөл, арга хэмжээний гэрээг байгуулж, 581.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээ

¹⁹ Үнэлгээний хороонд томилогдсон гишүүн бүр УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийн загварын дагуу тухайн худалдан авах ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчилтэй эсэхээ мэдэгдэнэ.

²⁰ Холбогдох маягтын дагуу үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл хөтлөх, шийдвэрийг гишүүдээр баталгаажуулах

худалдан авах ажиллагаагаар гүйцэтгэгч сонгон шалгараагүйтэй холбоотойгоор буцаан татагдаж, өмнөх оноос шилжих 578.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ажлыг үргэлжлүүлсэн байна.

Хэрэгжээгүй 7 төсөл, арга хэмжээний жагсаалт

Хүснэгт №4

(сая төгрөгөөр)

№	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг	ХАА-ны хэлбэр	Зарласан тоо
1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын ёслол хүндэтгэлийн өргөө засварлах ажил	50	ХА	4
2	Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгож, шинэчлэл хийх ажил	200	ЗҮ	2
3	Сүмбэр сум 1-р баг Худалдаачны гудамжны тохижилтын ажил	217.9	НТШ	2
4	Шивээговь сумын шинэ суурьшлын бүсэд худаг гаргуулах, ухаалаг систем суурилуулах ажил	89.1	ХА	2
5	Эко сүмбэр хотхоны гадна бохирын засварын ажил	19.5	ШГ	0
6	Дулааны станцын дулаан дамжуулах төвүүдийн мэдээлэл, холбооны шугамын ажлын зураг, төсөв боловсруулах ажил	5.0	ШГ	0
7	Сүмбэр сумын 2 дугаар багийн гэр хорооллын хэсэгт гэрлэн дохиотой авто замын уулзвар байгуулах зураг, төсөв хийлгэх	5.0	ШГ	0
Нийт		586.5		

(Эх сурвалж: Орон өмчийн газрын мэдээ, анхан шатны баримт)

Аудитын илрүүлэлт: Зөвлөмж

Дээрх төсөл, арга хэмжээнүүдийг аймгийн Орон нутгийн өмчийн газраас тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нөхцөлийг судлан дахин зарлах зөвлөмжийг захиалагчид хүргүүлдэг боловч тендерийн баримт бичгийн агуулгыг өөрчлөлгүйгээр 2-4 удаа зарласан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.1²¹-т заасныг зөрчсөн бөгөөд хөрөнгө оруулалтын төлөвлөгөө бүрэн хэрэгжихгүй байхад нөлөөлсөн байна.

2021 онд гэрээ байгуулсан “1-р багт дахин төлөвлөлт хэрэгжүүлэх байршилд ерөнхий төлөвлөгөөний зураг төсөв боловсруулах”, “Нийтийн эзэмшлийн байрнуудын цахилгааны шит монтаж засварын ажил”-ууд нь нийт 108.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй ба 2022 онд 28.6 сая төгрөгөөр санхүүжих 2 төсөл, арга хэмжээ гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалан удааширч 2023 онд шилжин хэрэгжихээр болжээ.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн өмнөх оноос сайжирсан боловч ашиглалтад хүлээн авсан 2 төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу ашиглаагүй, ажлын даалгаварт зайлшгүй хийгдэх ёстой ажлыг тусган хийхгүй байгаа нь хэрэгжилт, үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

²¹ 30.4.1.тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах

Аудитын илрүүлэлт: Зөвлөмж	Зураг
1.Төсвийн тодотгол хийж худалдан авсан 2 ширхэг “Бага оврын цахилгаан автобус”-ыг зориулалтын дагуу ашиглаагүй байна. Тус автобусыг худалдан авахаар төлөвлөхдөө урьдчилсан судалгаа хангалтгүй хийсэн, орон нутгийн онцлогийг харгалзан үзээгүй, хариуцах газар нэгжийг тодорхойлоогүй, хүний нөөцийг бэлтгээгүй зэргээс шалтгаалан зориулалтын дагуу ашиглаагүй. 2“Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн дээвэр засварын ажил”-д дээврийн босоо хана /парпет/-ны засварыг ажлын тоо хэмжээнд тусгаагүйгээс парпетны төмрийн бэхэлгээ зарим хэсгээр сул хийгдэж, салхины нөлөөгөөр урагдсан. Мөн биеийн тамирын заалны дээвэр, барилгатай холбосон хэсгээр цасны ус нэвтэрсэн. 4.“Зохиомол хээлтүүлгийн явуулын пункт”-ыг зориулалтын дагуу ашиглаагүй, гүйцэтгэгч байгууллагын хашаанд бараа материал хураасан. 5.“Сүмбэр сум 2-р баг бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт”-н ажлыг Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-д эзэмшүүлсэн боловч хараа хяналт сул байгаагаас сандлуудыг эвдэлж хэмхэлсэн, хогийн савнуудыг сууринаас нь салгаж унагаасан, тоглоомын талбайн зарим тоглоомыг эвдэлж сүйтгэсэн. 6. “Цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх байрны бохир усны шугам холбох, дээвэр засварын ажил”-ын хувьд дээврийн хар цаасны ирмэгээр цасны ус нэвтэрсэн.	   
7.“Орон нутгийн өмчийн байгууллагуудын их засвар”-ын ажлын хүрээнд хийгдсэн Баянтал сумын 4-р сургуулийн урлаг заалны засварын ажлын даалгавар цонх солихоор тусгасан боловч цонхны амлагаа хийх ажлыг төлөвлөөгүй. Дээвэр засварын ажлыг хийхгүйгээр дотоод заслын ажлыг гүйцэтгэсэн.	

Эдгээр нь Иргэний тухай хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.3а²², 350.1.3б²³ 351 дүгээр зүйлийн 351.1.4²⁴-д заасныг тус тус зөрчсөн байна.

Захиалагч болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу баталгаат хугацаанд 5-р сургууль, цагдаагийн хэлтсийн дээврийг засварлуулах, зохиомол хээлтүүлгийн пунктыг гүйцэтгэгч байгууллагаас авч зориулалтаар нь ашиглах, бага оврын цахилгаан автобусанд үүссэн нөхцөл байдлыг судлан эдийн засгийн эргэлтэд оруулах, Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ иргэд

²² 350.1.3 а/ ажил гүйцэтгүүлэхээр захиалагчийн шилжүүлсэн материал, ажил гүйцэтгэх аргын талаар захиалагчийн өгсөн зааварчилга нь ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр байвал;

²³ 350.1.3 б/ ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, ажил гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон.

²⁴ 351.1.4.ажил гүйцэтгэгчийн тавьсан шаардлагын дагуу чанар муутай буюу шаардлага хангахгүй материалыг сольж өгөх, буруу зааварчилгаагаа өөрчлөх, ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөх бусад нөхцөл байдлыг арилгах талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээ авах.

олон нийттэй хамтран хяналт тавьж хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг нь хангаснаар хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой байна.

Иймд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, зориулалтын дагуу ашиглах зөвлөмжийг захиалагчид хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

В.2.3 Тайлант хугацаанд шинэ болон шилжих хөрөнгө оруулалтад 3,587.9 сая төгрөг батлагдсанаас 38 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 2,411.1 сая төгрөгийн санхүүжилтийг хууль, журам болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу олгож, 1,176.8 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

В.2.4 Аймгийн ЗДТГ-аас ГХБХБГ-тай захиалагчийн хяналтын гэрээ байгуулж, 29.6 сая төгрөгийг хяналтын зардалд авсан бөгөөд зардлын 70%-ийг ГХБХБГ, 30%-ийг АЗДТГ-т хуваарилсан байна.

Уг гэрээний дагуу 1,676.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 барилга байгууламж, 430.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлж ажлын үе шат бүрд гүйцэтгэлийг хянаж баталгаажуулжээ.

Зураг төсөв зохиогчийн хяналт тавих шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт

Хүснэгт №5

(сая төгрөгөөр)

№	ТАХ-ний нэр	ЗТ-ийн зохиогчийн нэр	Төсөвт өртөг	Хяналт хэрэгжүүлсэн эсэх		Тайлбар
				Тийм	Үгүй	
1	Сүмбэр сумын Найрамдал хотхонд шинээр баригдаж байгаа барилгуудын цахилгаан хангамжийн ажил	Содон проект ХХК	339.4		1	Зохиогчийн хяналтын гэрээгүй, үе шат бүрт хяналт тавиагүй.
2	Халуун усны барилгын ажил /Сүмбэр сум, 2 дугаар баг/	Баяр мега сервис ХХК	357.0		1	Зохиогчийн хяналтын гэрээ байгуулсан боловч үе шат бүрт хяналт тавьсан тайлангүй.
3	Аймгийн төвийн гэрэлтүүлгийн ажил	Перфект солюшн энд инженеринг	246.8	1		Хяналт хэрэгжүүлсэн
4	Сүмбэр сум 2-р баг бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт	Баярмега сервис	439.2	1		Хяналт хэрэгжүүлсэн
Нийт			1,382.5	2	2	

(Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын ажлын гэрээ, хяналтын тайлан)

Аудитын илрүүлэлт: Зөвлөмж

Захиалагчийн зүгээс зураг төсвийн зохиогч компаниудтай хяналтын гэрээ байгуулаагүйн улмаас 2 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд зохиогчийн хяналт тавигдаагүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5²⁵, 38 дугаар зүйлийн 38.1.4²⁶, Засгийн газрын 2021 оны 160-р тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.3²⁷-т заасныг тус тус зөрчсөн бөгөөд хяналт хэрэгжихгүй байх нь барилга байгууламж зураг төсвийн дагуу баригдахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналт:

²⁵ 37.1.5.барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах;

²⁶ 38.1.4.зохиогчийн техникийн хяналтыг барилгын ажлын үе шатанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

²⁷ 5.2.3.Захиалагч нь барилга байгууламжийн ажлын үе шат бүрт зохиогчоор хяналт тавиулж, дүгнэлт гаргуулна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2019-2021 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар нийт 549.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж 6.0 сая төгрөгийн төлбөрийн акт, 532.6 сая төгрөгийн албан шаардлага, 11.1 сая төгрөгийн зөвлөмж өгч хэрэгжилтийг тооцсон байна.

В.2.5 2022 онд нийт 33 төсөл, арга хэмжээ 100% хэрэгжсэнээс 32 төсөл, арга хэмжээнд улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан байна. Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс нь ашиглалтад хүлээн авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулжээ. Мөн хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэж, гэрээний хугацааг баримтлаагүй 5 төсөл, арга хэмжээнд 3.4 сая төгрөгийн алданги тооцож хүү, торгуулийн орлого дансанд төвлөрүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:-Албан шаардлага

Ашиглалтад хүлээн авсан 125.7 сая төгрөгийн 9 зураг төсөв, 158.0 сая төгрөгийн 2 ширхэг бага оврын цахилгаан автобусыг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2²⁸, 2021 оны 160-р тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.31²⁹-т заасныг зөрчсөн байна.

Аудитаар нийт 559.3 сая төгрөгийн 12 зөрчил илрүүлж 559.3 сая төгрөгийн 4 албан шаардлага, 6 зөвлөмж өглөө.

²⁸ 14.4.2 бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

²⁹ 4.1.31.Эцсийн санхүүжилтийг авахад тухайн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говьсүмбэр аймагт хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт 83.3%, Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичигт 100% нийцсэн байна

1. Төсөл арга хэмжээ нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна
2. Шинээр хэрэгжих 3 барилга байгууламжийн ажлаас 1 буюу 33.3 хувь нь хууль батлагдсаны дараа техникийн нөхцөл авч, зураг төсөв нь магадлалаар баталгаажсан байна.

Бүлэг-2

Улсын төсвөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд тавих хяналт сул байгаа нь хууль тогтоомж зөрчигдөх шалтгаан болж байна.

1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.
2. Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа, ковид-19 цар тахлын улмаас Төсвийн тухай хуульд заасан хугацаанд ашиглалтад ороогүй, удааширсан 2 барилга байгууламж байна.
3. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 75.7 хувьтай, зорилтот түвшиндээ хүрээгүй байна.
4. Санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслээгүй, гэрээний хугацаанд олгоогүй байна.
5. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд ТЕЗ-ийн дотоод аудит болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна
6. Төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан боловч нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүй байна.

Бүлэг-3

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний бэлэн байдал, үр ашгийг судалгааг бодитой тооцоогүйгээс 158.0 сая төгрөгийн ашиглалтгүй хөрөнгө бэлтгэсэн байна.

1. Орон нутгийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээ 2 төсөл, арга хэмжээ батлагдсан байна
2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн өмнөх оноос сайжирсан боловч төлөвлөлтөөс шалтгаалсан зөрчил давтагдан гарсаар байгаа нь хэрэгжилт, үр дүнд сөргөөр нөлөөлж байна

ЗӨВЛӨМЖ

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Сүмбэр сумын 150 ортой цэцэрлэгийн барилга, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилгын ажлыг эрчимжүүлж, гэрээний сунгалт хийсэн хугацаанд ажлыг дуусгах

Аймгийн ЗДТГ-ын даргад:

1. Улс, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, их засварын ажлын зураг төсөл, төсвийг төсвийн тухай хууль батлагдахаас өмнө магадлалаар баталгаажуулж хуулийн шаардлагад нийцүүлэх, батлагдсан зураг төсөвт өөрчлөлт оруулахгүй байх
2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламжийн ажилд зохиогчийн хяналт тавих гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, шаардлагатай тохиолдолд гэрээг цуцалж зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан хяналтыг хэрэгжүүлэх
3. 2-4 удаа зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон шалтгаан нөхцөлийг тогтоон өөрчлөлт оруулах, ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг биелүүлэх
4. Тайланд дурдсан 7 төсөл арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн хангалтгүй тул захиалагч болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу баталгаат хугацаанд 5-р сургууль, цагдаагийн хэлтсийн дээврийг засварлуулах, зохиомол хээлтүүлгийн пунктыг гүйцэтгэгч байгууллагаас авч зориулалтаар нь ашиглах, бага оврын цахилгаан автобусанд үүссэн нөхцөл байдлыг судлан эдийн засгийн эргэлтэд оруулах, Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ иргэд олон нийттэй хамтран хяналт тавьж хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг нь хангаснаар хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх

Аймгийн ОНӨГ-ын даргын үүрэн гүйцэтгэгчид:

1. Үнэлгээний хорооны баримт бичгийг гишүүдийн гарын үсгээр баталгаажуулан, иж бүрдлийг хангаж архивлах

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас: 7054 3367,
И-мэйл: govsumber@gazar.gov.mn,
Вэбсайт: www.govsumber.gazar.gov.mn

2023.04.19 № 01/131
тавай 2023.04.18-ны № 94 -т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.САРАНТУЯА ТАНАА

А/а Т.Дорхонбаяр
Саналтай танилцуул,
тайланг бүтээх

Анх
11/19

Санал хүргүүлэх тухай

Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитийн тайлангийн төсөлтэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй тохижилт, засварын ажилд ажлын зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, магадлалаар оруулж байх
- Барилга угсралт, засвар, шугам сүлжээний ажилд ерөнхий захиалагч талаас зохиогчийн хяналтыг ажил бүр дээр үр дүнтэй хийлгэх
- Барилга угсралт, засвар, шугам сүлжээний ажил гүйцэтгэх явцад батлагдсан зураг төсөлд өөрчлөлт оруулахгүй байх, ажил эхлэхээс өмнөх боловсруулалтын баримт бичиг дээр төсөв тооцооллыг нарийвчлан сайн хийж байх зэрэг саналуудыг тусгах саналтай байна.

ДАРГА

БИОТГОНЧИМЭГ

4200000030

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас/Факс: (976) 7054 3118,
И-мэйл: zdtg.gsa@gmail.com, Вэбсайт: www.govisumber.gov.mn

2023.04.19 № 01/417
танай 2023.04.18-ны № 92 -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.САРАНТУЯА ТАНАА

Амал аудитар
Б.Дарханбаатар
Санал, нотлох баримттай
танилган таалаар
сруулах саналтай
танилгуулах 2023.04.19

Санал хүргүүлэх тухай

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн маягтад тусгагдсан “Шивээговь сумын 150 ортой цэцэрлэгийн барилгын ажил”-ын зураг төсвийг 2015 онд хийлгэснийг 2022 онд үнийн өсөлт стандарт өөрчлөгдсөнтэй холбогдуулан шинэчлүүлж Барилгын хөгжлийн төвөөр батлуулсан мөн “Аймгийн төвийн авто замын засварын ажил”-ын зураг төсвийг 2015 онд хийлгэснийг 2020 онд үнийн өсөлттэй холбогдуулан шинэчлүүлж Зам, тээврийн хөгжлийн төвөөр батлуулсан тул тухайн алдаа зөрчлийн дүгнэлтийг залруулж өгнө үү.

Тухайн алдаа зөрчлийг залруулахтай холбоотой нотлох баримтыг хавсралтаар хүргүүлэв.

Хүндэтгэсэн

ДАРГА



Д.СОДНОМ

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

ГХБХБГ-аас ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

1. “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй тохижилт, засварын ажлын зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хянуулж магадлалаар баталгаажуулж байх” гэсэн санал нь аудитын тайлангийн зөвлөмжийн хэсэгт тусгагдсан тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.
2. “Барилга угсралт, засвар, шугам сүлжээний ажилд ерөнхий захиалагч талаас зохиогчийн хяналтыг ажил бүр дээр нь үр дүнтэй хийлгэх” гэсэн санал нь аудитын тайлангийн зөвлөмжийн хэсэгт тусгагдсан тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.
3. “Барилга угсралт, засвар, шугам сүлжээний ажил гүйцэтгэх явцад батлагдсан зураг төсөлд өөрчлөлт оруулахгүй байх, ажил эхлэхээс өмнөх боловсруулалтын баримт бичиг дээр төсөв тооцооллыг нарийвчлан хийж байх “ саналыг хүлээн авч “Улс, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, их засварын ажлын зураг төсөл, төсвийг төсвийн тухай хууль батлагдахаас өмнө магадлалаар баталгаажуулж хуулийн шаардлагад нийцүүлэх, батлагдсан зураг төсөвт өөрчлөлт оруулахгүй байх” гэж өөрчлөн найруулав.

Аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

1. “Шивээговь сумын 150 ортой цэцэрлэгийн барилгын ажил”-ын зураг төсөл, төсөв 2015 онд магадлалаар баталгаажуулсан боловч Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд батлагдахдаа Төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлага болох зураг төсөл, төсөв нь сүүлийн 2 жилд магадлалаар баталгаажсан байх шаардлагыг хангаагүй бөгөөд Барилгын хөгжлийн төвийн 2022 оны 06 сарын 30-ны өдрийн 1078/2022 магадлалын дүгнэлтээр тус цэцэрлэгийн төсөвт өртгийг 3,833.6 сая төгрөгөөр баталсан байна. Иймд АЗДТГ-ын ирүүлсэн тайлбарыг үндэслэлгүй гэж үзэн тайланд өөрчлөлт оруулаагүй.
2. “Аймгийн төвийн авто засварын ажил”-ын зураг төсвийг 2015 онд магадлалаар баталгаажуулж, Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль батлагдахаас өмнө буюу 2020 онд төсөвт өртгийг дахин шинэчлүүлсэн нь Төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлага болох зураг төсөл, төсөв нь сүүлийн 2 жилд магадлалаар баталгаажсан байх шаардлагыг хангаж байна. Иймд АЗДТГ-ын ирүүлсэн саналыг хүлээн авч аудитын тайлан, асуудлын бүртгэлээс хасаж шийдвэрлэлээ.